



НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗАР
ПРОКУРОРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс
татгалзах тухай

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор Я.Мөнхзаяа би, тус дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Ү.Батсайхан нь Ардчилсан намын дарга С.Эрдэнээс гаргасан СБ1-315 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад, 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай санал гарган, хяналтад ирүүлснийг 2021 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч хянаад ОЛСОН нь

АН-ын дарга С.Эрдэнээс гаргасан "...Ц.Туваан нь хэвлэл мэдээллээр өгсөн ярилцлагадаа Ардчилсан намын тамга надад байна гэж ярьж байна...үүнээс үзэхэд Ц.Туваан нь Ардчилсан намын тамгыг санаатайгаар зориуд өөртөө нуусан" ...гэх үйлдэлд холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулжээ.

Гомдол мэдээллийг шалгах явцад материалд гэрч Г.Батбаярын "...Ц.Туваан гэдэг хүн Ардчилсан намын дэд дарга байсан бөгөөд энэ хүн 2020 оны Улсын Их хурлын ээлжит сонгуулиар огцорсон, гэвч намын үндсэн дүрмийн 3.10.1.1 дэх хэсгийн заалтаар бол Ардчилсан намын дарга болон 6 дэд дарга, Ерөнхий нарын бичгийн дарга нар огцорсон тооцогддог, ингээд намын дарга С.Эрдэнэ огцорсон дэд дарга болох Ц.Туваанд 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Ардчилсан намын 111.... тоот тамгыг дараагийн Ардчилсан намын шинээр сонгогдох даргад хүлээлгэн өгөх үүргийг сануулан хадгалуулахаар өгсөн. 2020 оны 08 дугаар сарын 23-ны өдөр Ардчилсан намын даргыг хуралдуулах товыг зарлаад тэгээд өгсөн юм, тэгтэл энэ өдөр Ц.Туваан нь намын даргыг сонгох хурлыг хуралдуулахгүй болиулаад тэгээд 2020 оны Орон нутгийн сонгууль болсон, энэ үед Ардчилсан нам ялагдсан, орон сонгууль Ц.Туваан өөрөө Ардчилсан намыг толгойлон оролцсон юм.

Үүнээс Ц.Туваан нь дүрмийн бус үйл ажиллагаа их явуулсан бөгөөд /олон албан тушаалтан халж, сольсон, санхүүгийн үйл ажиллагаа явуулан мөнгө төгрөг орж гаргасан гэх мэт/ 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Ардчилсан намын дүрэмд өөрчлөлт оруулах их хурлыг зарласан, тэр үед нь ингэж болохгүй, та тамга хадгалж чадахгүй байна тамгаа эргүүлэн өг гэсэн шаардлага тавьсан. ...Түүнээс хойш 4 хоног таг чимээгүй байсан бөгөөд албан бичиг хүлээн авсан, утсаар ярьсан тамга өг гэсэн. Шаардлагыг мэдсэн, гэтэл хариу өгөөгүй, бид нарын зүгээс 24 цагийн дотор тамга өг гэсэн шаардлага тавьсан, гэтэл 4 хоног алга болсон. Ингээд бид нарын зүгээс тамгыг үрэгдүүлсэн байна гэж ойлгоод 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн Ерөнхий газарт С.Эрдэнэ өөрийгөө намын дарга хэвээрээ байгаа гэдгээ тодорхойлсон бичиг баримтын хамт Намын тамгыг

D:\Blank-2021\Тогтоол.docx

0000008104

2021. 04. 02

УЗМ03297 5083231

шинээр авах талаар хүсэлт гаргасан, ингээд эрх Улсын бүртгэлийн Ерөнхий газраас захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заагдсан талуудыг оролцуулсан сонсох ажиллагааг 3 хоног явуулсан ингээд 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Ардчилсан намын тамгыг шинээр гарган өгсөн.

Улсын бүртгэлийн газарт тамга олгох хүчингүй болгох эрх нь байгаа гэдгийг 2021 оны 01 сарын 14-ний өдрийн Улсын дээд шүүхийн Иргэний танхимын 04 дүгээр тогтоолын үндэслэх хэрэгт заан өгсөн. Ингээд 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр тамга шинээр авсан чинь 111 тоот тамгыг Ц.Туваан гаргаж ирээд надад тамга байна гээд энэ хүчингүй болсон тамгаар Захиргааны хэргийн шүүх болон бусад эрх бүхий байгууллагад өргөдөл гомдол гаргаж эхэлсэн, тэр хүчингүй болгосон тамга дарж хүчинтэй мэтээр гаргаж эхэлсэн, ийм учир Ц.Туваан гэдэг хүн Ардчилсан намын тамгыг нуусан байна гэж мэдсэн. ...Улсын бүртгэлийн газартай холбоотой тамга олгосон маргаан нь Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхэд байгаа, шүүхийн шийдвэр гараагүй байна. Ардчилсан намын тамга, тэмдэг, туг хадгалах дүрэм гэж байгаа түүнд Намын даргад тамга, намынхаа байранд хадгалагдана гэж байгаа..." гэх мэдүүлэг болон холбогдох материал баримтууд авагджээ.

Дээрх үйл баримтуудаар уг үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулаагүй гэж дүгнэв.

Учир нь Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, Ц.Туваан нарын дунд үүссэн маргааны асуудал нь намын тамгыг тодорхой шалтгааны улмаас хүлээлгэн өгсөн, харин буцааж авах шаардлага бүхий албан бичиг хүргүүлсэн боловч, ямар нэгэн хариу ирүүлээгүй талаар гарсан байна.

Түүнчлэн дээрх үйлдлийн улмаас үүссэн маргаан нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжгүй бөгөөд уг асуудлыг зохицуулсан эрх зүйн харилцаагаар шийдвэрлэх боломжтой тул хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардчилсан намыг дарга С.Эрдэнээс гаргасан СБ1-0315 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсугай.

2. Энэ талаар гомдол гаргагч С.Эрдэнэд мэдэгдсүгэй.

3. Энэхүү шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Дээд шатны прокурорт буюу Дүүргийн Ерөнхий прокурорт гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ХЯНАЛТЫН ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ДЭД ЗӨВЛӨХ



Я.МӨНХЗАЯА

